

ШИЛЖИЛТИЙН ҮЕИЙН МОНГОЛ-ЯПОНЫ ХАРИЛЦАА

Ж. Уянга*

Монгол улс Япон улстай 1972 оны 2-р сарын 24-нд албан ёсоор дипломат харилцаа тогтоосноос хойш хоёр орны харилцаа тогтвортой хөгжиж ирсэн юм. Энэхүү харилцаа нь 80-аад оны эцэс хүртэл хэвийн тогтвортой боловч “урсгал” шинжтэй байв. Харин 90-ээд оны эхээр манай улсад ардчилал, өөрчлөлт шинэчлэлтийн бодлого явагдан, дэлхийн улс орнуудтай, хамтын ажиллагаагаа өргөжин тэлэх болсон нь энэхүү харилцаанд ч нөлөөлсөн юм.

Монгол улс гадаад олон улстай харилцах харилцаандаа нээлттэй бодлого баримталж эхэлсэн нь ЗХУ, Зүүн Европын социалист орнуудыг түшиглэх урьдын хандлага өөрчлөгдөж, өрнөдийн орнуудтай харилцаагаа гүнзгийрүүлж эхэлсэн юм.

Азид ардчиллын нөлөөг хамгийн түрүүнд хүлээж авсан социалист орон бол Монгол орон юм. Япон улс ардчиллыг дэмжигч орны хувьд Монгол оронд өрнөж буй ардчилал, өөрчлөлт шинэчлэлтийг анхнаасаа л тууштай дэмжиж ирсэн юм.

Монгол, Япон улс нь Зүүн хойг Азийн дэд бүсэд багтаж, Ази, Номхон далайн бүс нутагт оршдог. Япон улс Монгол улстай идэвхтэй харилцааг хөгжүүлэх нь Азийн бүс нутгийн энх тайван, тогтвортой байдалд чухал ач холбогдолтой гэсэн “Дэлхийн хэмжээний Япон гүрний” ойлголтод тулгуурласан бодлогын нэг хэсэг оршиж байгаа билээ. Нөгөөтэйгүүр, Монгол улсын хувьд Ази, Номхон далайн бүс нутгийн хөгжил, хамтын ажиллагаанд эрх тэгшээр идэвхтэй оролцох зорилтыг хэрэгжүүлэхэд Япон улсын дэмжлэг, туршлага онцгой ач холбогдолтой юм. Түүнчлэн, урьд нь бусдаас хараат байсан Монгол улсад өнөөдөр Азийн орнуудын хөгжилд тусламж дэмжлэг үзүүлдэг, дэлхийд техникийн дэвшил, эдийн засгийн чадавхиараа тэргүүлдэг Япон орны тусламж дэмжлэг юу юунаас чухал билээ.

Японы засгийн газар манай оронд өрнөсөн өөрчлөлт шинэчлэлтийг эхнээс нь дэмжиж, шилжилтийн үеийн бэрхшээлийг

* Ж.Уянга - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

даван туулахад санхүү, эдийн засгийн тусламж үзүүлэхийн зэрэгцээ дэлхийн аж ахуйн хэлхээ холбоонд нэгдэх, олон улсын эдийн засгийн байгууллагуудад элсэн орох Монгол улсын хүсэл эрмэлзлэлийг зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлсэн үеэс дэмжиж байгаа нь монгол-японы харилцааны нэг чухал ололт болсон юм.

Япон улс манай улсад ардчилал, зах зээлийн шинэчлэлд туслах зорилгоор Монголд хандивлагч орнуудын зөвлөлгөөнийг санаачлан Дэлхийн банк, Олон Улсын валютын сантай хамтарч нийт найман удаа зохион байгуулаад байна.

Сүүлийн арван жилд хоёр орны Засгийн газрын тэргүүн нар, өндөр хэмжээний төлөөлөгчид ойр ойрхон харилцан айлчилсан явдал нь хоёр орны найрсаг харилцааг хөгжүүлэн өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой болсон төдийгүй хоёр орны харилцааг шинэ шатанд гаргаснаараа онцлогтой юм.

Мөн хөгжингүй том орон Японтой манай улс богино хугацаанд харилцаагаа идэвхжүүлж, 1991 оны 8-р сард Япон Улсын Ерөнхий сайд Т.Кайфу өрнөдийн орнуудын удирдагчдаас анх түрүүн манай улсад албан ёсны айлчлал хийсэн нь дэлхийн бусад гол орнуудын дэмжлэгийг хүлээхэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн юм.

Ерөнхийлөгч Н.Багабанди Монгол Улсын төрийн тэргүүний хувьд Япон улсын засгийн газрын урилгаар Япон улсад 1998 оны 5-р сард албан ёсны айлчлал хийсэн юм. Айлчлалын үеэр 5-р сарын 14-нд Токио хотноо гаргасан Монгол улс, Японы улсын найрамдал, хамтын ажиллагааны тухай хамтарсан мэдэгдэлд хоёр орны харилцааны үндсэн зарчим, тодорхой чиглэлүүдийг хоёр тал доорхи 10 зүйлээр томъёолсон юм.

1.Монголын ардчилал, шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэх нь Зүүн хойт Азийн энх тайван, хөгжил цэцэглэлд тус дөхөм болно гэж хоёр тал санал нэгтэй үзжээ.

2.Харилцан ойлголцол итгэлцлийг нэмэгдүүлэх замаар иж бүрэн түншлэлийн харилцааг ХХI зуунд бэхжүүлэх зорилтыг дэвшүүлэв.

3.Хоёр орны төр засгийн хоорондын улс төрийн яриа хэлэлцээ өргөжиж байгаа нь Монгол-Японы харилцааны хөгжилд үр ашгаа өгч байгааг дурьдаад цаашид олон улсын болон бүс нутгийн хэмжээний асуудлууд, харилцан сонирхсон асуудлаар санал солилцож байх.

4. Монголын тал бие даасан хөгжлөө хангахын төлөө бүх талаар хүчин чармайлт гаргаж, тусламжийн төслүүдийг үр ашигтай хэрэгжүүлэх, Японы тал цаашид ч дэмжиж туслахад бэлэн байгаагаа тус тус илэрхийлээд хоёр тал Монгол, Японы харилцааг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэхийн тулд эдийн засгийн хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэх, Монголд хөрөнгө оруулахыг хөхүүлэн дэмжих нь чухал гэж үзэв. Монголын тал гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд хөрөнгө оруулалтын нөхцөлийг улам сайжруулах арга хэмжээ авахаа нотлов.

5. Хоёр тал Монгол, Японы ард түмний найрсаг харилцааг бэхжүүлэхэд соёл боловсрол зэрэг салбарын хамтын ажиллагаа чухал ач холбогдолтойг тэмдэглэв.

6. Залуучуудын солилцоог хөгжүүлэхийн ач холбогдлыг хоёр тал санал нэгтэй тэмдэглээд Японы тал ирэх 3 жилд Монгол улсаас мэргэжил дээшлүүлэгч, оюутан болон бусад шугамаар нийт 500 залуусыг хүлээн авахад бэлэн байгаагаа мэдэгдэв.

7. Байгаль орчныг хамгаалах салбарт хоёр тал хамтран ажиллах.

8. Зүүн хойт Азид аюулгүй байдал тогтоох нь тус бүс нутагт орших хоёр орны нийтлэг ашиг сонирхлын асуудал бөгөөд энэ бүс нутаг дахь улс төр, аюулгүй байдлыг хангах нь чухал гэж хоёр тал санал нэгтэй үзэв.

9. Япон улс НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүний хувьд олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хамгаалахад нийцүүлсэн үүрэг гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлэхээ Монгол улс дахин илэрхийлэв.

10. Олон улсын эдийн засгийн асуудлаар санал бодлоо солилцож байх, энэ талаар бололцооны хэрээр хамтран ажиллахаар тохиров.

1993 оны 11-р сард Япон Улсад Монгол улсын Ерөнхий сайд П.Жасрай албан ёсны айлчлал хийв. Айлчлалын явцад “Агаарын харилцааны” хэлэлцээр байгуулагдаж, “Төмөр замын тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх хөтөлбөр” төсөлд 30 сая ам.долларын засгийн газрын хөнгөлөлттэй зээл, Монгол улсын гадаад хэлний дээд сургуульд хэлний сургалтын танхимын тоног төхөөрөмж нийлүүлэх 50 сая иенийн соёлын буцалтгүй тусламж олгохоор болжээ.

Мөн Монгол-Японы харилцааны түүхэнд болсон онцгой

чухал үйл явдал бол монгол-японы дипломат харилцаа тогтоосны 25 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн явдал юм. Энэ үеэр Монгол улсын ерөнхий сайд М.Энхсайхан Япон Улсад 1997 оны 2-р сард ажлын айлчлал хийсэн бөгөөд Монгол улсад Японы засгийн газраас төслийн бус буцалтгүй тусламжаар 2 тэрбум иен, нүүрсний том уурхайнуудын хүчин чадлыг сайжруулахад зориулж 5,8 тэрбум иенийн хөнгөлөлттэй зээл, 250 сая иенийн хүнсний тусламж олгохоор болжээ. Мөн энэ үеэр олон нийтийг хамарсан томоохон арга хэмжээнүүд зохиогдож хоёр орны ардын урлаг, дуу хөгжим, зан заншил зэргийг харилцан танилцуулсан юм.

Япон улсын Ерөнхий сайд Кейзо Обучи 1999 оны 7-р сард Монгол улсад албан ёсны айлчлал хийсэн нь хоёр орны хоорондын иж бүрэн түншлэлийн харилцаанд шинэ хуудас нээсэн чухал ач холбогдолтой үйл хэрэг болов. Айлчлалын үеэр хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор 500 сая иенийн буцалтгүй тусламжийг олгож, Монгол улсын соёлын өвийн төвд 48,1 сая иенийн түүх дурсгалын үнэт зүйлсийг хадгалж хамгаалахад зориулсан тоног төхөөрөмж нийлүүлэхээр болж, Япон улсын сайн дурынхныг Жайка байгууллагын шугамаар Монгол улсад илгээх хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болов.

Шинэ зууны босгон дээр 2001 оны 2-р сард Монгол улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр Япон улсад албан ёсны айлчлал хийсэн нь манай орны хүнд хэцүү шилжилтийн энэ үед чухал ач холбогдолтой болсон юм. Энэ айлчлалын үеэр Ерөнхий сайд Н.Энхбаяр Япон улсын Ерөнхий сайд Ё.Моритой хэлэлцээ хийсэн юм. Энэ айлчлалын үеэр:

1.Монгол оронд жил дараалан учирч буй зудын хор хохирлыг арилгахад зориулж өмнө олгосон 10 сая америк доллартай тэнцэх буцалтгүй тусламж дээрээ нэмж 300 сая иений яаралтай буцалтгүй тусламж олгохоор болжээ.

2.Техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулж, Монгол улсад Японы хөгжлийн албан ёсны тусламж олгох тусгай хөтөлбөр боловсруулж, IV цахилгаан станцыг шинэчлэх 6.1 тербум иений зээл олгохоор болжээ.

3. Монгол улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах

4.Боловсролын солилцоог нэмэгдүүлж, 20 орчим оюутныг Японы зардлаар нэмж сургах, хувиараа суралцаж байгаа оюутны хөнгөлөлтийн асуудлыг судлах, түүнчлэн “Хөрөнгө оруулалтыг

харилцан хамгаалах, хохүүлэн дэмжих тухай хэлэлцээр"-т, "IV цахилгаан станцыг шинэчлэх хөнгөлөлттэй зээл олгох тухай", "МУИС-ийн хэвлэлийн тоног төхөөрөмжийг шинэчлэх тухай" ноотуудад гарын үсэг зуржээ. МУИС-ийн хэвлэлийн тоног төхөөрөмжийг шинэчлэх буцалтгүй тусламж нь 300 мянга орчим америк доллар юм.

Энэхүү айлчлалууд нь хоёр орны хоорондын иж бүрэн түншлэлийг шинэ агуулгаар баяжуулсан, хоёр орны ард түмнүүдийн ойр дотно харилцаа, харилцан ойлголцлыг улам гүнзгийрүүлэхэд бодит үр дүнгээ өгсөн чухал үйл явдлууд болж чаджээ.

Монгол-Японы харилцаа, хамтын ажиллагаа зөвхөн улс төр төдийгүй, худалдаа, эдийн засаг, соёл боловсрол, шинжлэх ухаан болон хүмүүнлэгийн салбарт идэвхтэй хөгжиж байна.

Өнөөдөр манай улс Японы Иточү, Сүмитомо, Мицүбиши, Мицүи, Нишшо-Ивай, Марубэни, Сони, Хитачи, Хонда, Ямаха, Осака Кашимир зэрэг томоохон пүүс, үйлдвэрлэгчидтэй худалдаа эдийн засгийн харилцаа тогтоож хамтран ажиллаж байна. Мөн техникийн тусламжийн хүрээнд Японы мэргэжилтнүүдийг урьж ажиллуулах, монгол мэргэжилтнийг Японд дадлага хийлгэх, курс семинарт оролцуулах зэрэг хамтран ажиллаж байна. Түүнчлэн Японы засгийн газрын зардлаар суралцаж буй манай оюутан, мэргэжил дээшлүүлэгчдийн тоо нэмэгдэж, япон, монгол хэлний чиглэлээр оюутан, багш нарыг харилцан солилцож, соёлын өдрүүд харилцан хийж, арга хэмжээндээ төлөөлөгчдийг харилцан урьж оролцуулах, манай тамирчид Япон улсад очиж бэлтгэл сургуулилт хийх зэрэг явдал нь ердийн хэрэг болжээ.

Сүүлийн үед Япон улсаас Монгол улсад Засгийн газрын болон олон нийтийн шугамаар үзүүлэх тусламж дэмжлэг өсөн нэмэгдсээр байна. Монголтой харилцах сайн дурын нийгэмлэгүүд Япон улсад Хоккайдогоос Окинава арлыг хамран 70 шахам ажиллаж байна.

Мөн энд нэгэн уулзалтын талаар дурдахгүй өнгөрч болохгүй нь. 2001 оны 10-р сарын 17-нд Монгол-Японы Нийгэмлэгийн шугамаар Монголд ирсэн Японы төрийн бус байгууллагын Сато тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзах аз завшаан надад тохиосон юм. Энэ байгууллагын улсууд Монголд тусламжийн бараа илгээдэг юм. Япон орон даяар Монгол оронд тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулж, 7 хоногт 1 контейнер тусламжийн бараа илгээдэг юм байна. Сато гуай: "Сая бид дандаа эмчилгээний бараа авчирсан.

Шилжилтийн энэ үед Монголд баян, ядуугийн ялгарал их гарч байна. Ялангуяа хүүхдийн асуудал хамгийн чухал. Хүүхдийг гудамжинд гаргах, хайхрахгүй байх явдал нь сэтгэл түгшээж байна. Иймд бид хүүхдийн хүмүүжилд анхаарлаа хандуулья гэж бодсон. Налайх дүүргийн иргэдээс Япон улсад 100 хүүхдийг техник, технологийн мэргэжил эзэмшүүлэх гэрээ байгуулсан. Тэгэх юм бол аав, ээжид нь ч амар байх болно. Японд аваачаад сургаад, ажлын хөлсийг нь өгнө. Одоо бид их хариуцлагатай болсон. Улсаа боддог хүүхдүүдийг л сургачих юм бол бидний зорилго, хүсэл биелэх нь тэр” гэж ярьж байлаа. Энэ бол японы ард түмний бидэнд тусламжийн гараа сунгасан зөвхөн нэгээхэн хэсэг юм.

Хандивлагч орнуудаас өнөөдрийн байдлаар манай оронд үзүүлж буй зээл тусламжийн 40 хувь нь Япон улсад ноогддог. Жишээ нь, 1991 онд Токио хотноо болсон хандивлагч орнуудын анхдугаар зөвлөлгөөнөөр манай улсад өвлийг даван туулахад хүнс, түлшний хомсдлыг арилгах зэрэг тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд 155 сая ам.долларын “яаралтай тусламж” олгосон нь 61 сая ам.долларын тусламжийг Япон улс гаргажээ. Хоёрдугаар зөвлөлгөөн 1992 оны 5-р сард Токио хотноо болж, Япон улс тээвэр, эрчим хүч, холбооны салбарын санхүүжилтэд туслах зорилгоор 67,5 сая ам.долларыг олгожээ. 1993 оны 9-р сард Токио хотноо болсон гуравдахь уулзалтаар Япон улс аж үйлдвэрлэлийн салбарын шинэчлэлд зориулж 41 сая ам.долларын тусламж үзүүлжээ. Дөрөвдэх зөвлөгөөн 1994 оны 10-р сард болж Монголын эрчим хүчний салбарын хөгжилд зориулж Япон улс 65 сая ам.долларыг олгохоор болжээ. Тавдахь уулзалт 1996 оны 2-р сард Токио хотноо болж, Монгол улсын эдийн засгийн хөгжлийн байдал, хувийн хэвшлийг хөгжүүлэхэд хандивлагч орнуудаас нийт 212,5 сая ам.долларын зээл тусламж үзүүлэв. Токиогийн зургадугаар зөвлөгөөнөөр Монгол улсын эдийн засгийн хөгжил, нийгмийн ээдрээтэй асуудлыг шийдэхэд нийт 250 сая ам.долларын дэмжлэг үзүүлсэн билээ.

1999 оны 6-р сард долдугаар зөвлөгөөн Улаанбаатар хотноо болж, нийгмийн шинэчлэл, ардчилал болон засаглалыг сайжруулахад зориулж нийт 320 сая ам.долларын тусламжийг ирэх 18 сарын хугацаанд олгохоор амлаж үүний дотор 115 сая ам.долларын зээл, тусламжийг Япон улсын Засгийн газраас дангаараа хэрэгжүүлэхээр амласан юм. Энэ тусламж зээл нь манай орны

шилжилтийн үеийн бэрхшээлүүдийг даван туулахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна.

Наймдугаар зөвлөлгөөн 2001 оны 5-р сард Парис хотноо болж, Зөвлөлдөх уулзалтын дүнд хандивлагч орон, олон улсын байгууллагуудаас 12 сарын хугацаанд нийт 330 сая ам.долларын зээл, тусламж үзүүлэхээр амлажээ. Энэ зээл, тусламж нь Монгол улсын макро эдийн засгийн тогтворжилтыг бататган, эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэрт байдлыг хангах, бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэх, экспортын шинэ зах зээлд нэвтрэн орох, ядуурлыг бууруулахад чиглэсэн юм.

Түүнчлэн, ажил хэргийн болон жуулчид, соёл, шинжлэх ухааны байгууллагын хүмүүс харилцан солилцох, айлчлах нь сүүлийн үед эрс нэмэгдэж монгол, япон хүмүүс, иргэд хоорондоо дотно холбоо харилцаатай болж, харилцан ойлгож итгэлцэх, нөхөрлөх явдал улам гүнзгийрэх нь хоёр орны харилцаа цаашид өргөжихийн бат суурь үндэс болж байна.

Ингэж харилцан бие бие ойлголцоход соёл, урлаг, шинжлэх ухааны өргөн хамтын ажиллагаа ихээхэн үр дүн үзүүлсэн юм.

Өнгөрсөн хугацаанд манай хоёр орон олон талын өргөн харилцааг тогтвортой хөгжүүлж, бие бие танин мэдэх, харилцан ойлголцох талаар ихээхэн амжилт олсон юм.

Цаашид монгол, японы тал бүрийн харилцаа, чухам эдийн засаг, худалдаа, соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагааг өргөжүүлэх бололцоо асар их байгаа юм. Японы техник, технологийн өндөр дэвшил, хөрөнгө капиталын хуримтлал, монголын байгалийн нөөц, үндэсний уламжлалт технологийн өв зэргийг оновчтой хослуулан хамтын ажиллагааг хөгжүүлбэл илүү үр дүн өгөх нь гарцаагүй.

Монгол-Японы харилцааг улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн болон бусад салбарт идэвхтэй хөгжүүлэх нь Монгол орон ардчилал, зах зээлийн замаар туйлбартай урагшлах, дэлхийн бусад орон, олон улсын байгууллагуудын хүрээнд үр дүнтэй хамтран ажиллах, Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдал, хамтын ажиллагааг хангаж бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. "Монгол-Японы харилцаа: эрт, эдүгээ" УБ.1998 он
2. "1990-ээд оны олон улсын харилцааны хандлагууд, Монгол улс – Их гүрнүүдийн харилцаа"
3. "Зууны мэдээ" №263 \837\, 2001.11.07
4. "Монгол улсын ерөнхий сайд Н.Энхбаярын Япон улсад хийсэн албан ёсны айлчлалын тойм" "Олон улс судлал" сэтгүүл, 2001 оны №1 дугаар
5. "Гадаад харилцаа" Монгол улсын Гадаад хэргийн яамны мэдээллийн товхимол №3 \98\ 2001.02.20, №6 \101\ 2001.05.31
6. "Өнөөдөр" сонин №04 \1466\, 2002.01.07
7. "Ардын эрх" 1998.05.13-15, 05.22, №114 \1893\
8. "Засгийн газрын мэдээ" 1997.02.20, №36 \728\
9. "Зууны мэдээ", 2001.05.24
10. "Зууны мэдээ" 2001.03.29, №73 \647\